



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

2007 оны 04 сарын 20 өдөр Даланзадгад

Дугаар 41

Газрын тухай хуулийн 20.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2007 оны 7/9 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газраас оруулж буй саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Аймгийн тусгай хэрэгцээний газарт мөрдөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг орон нутагт мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Эрдэнэбат/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2002 оны 66 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

ХУРЛЫН
С.ЦЭРЭНБАЯР